



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/364

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт багийн иргэн ардын авьяастан дуучин Г.Долгормаа, үндэсний хувцас урлаач Х.Буянхишиг нарт Тува улсад болох “Ээжийн алдар” олон улсын фестиваль наадамд оролцоход дэмжлэг үзүүлж 300.000 төгрөгийг олгосугай.

2. Уг зардалд шаардагдах 300.000 төгрөг /Гурван зуун мянган/ -ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ